



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот


Г Дүрэм батлах тухай Г

Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:


1."Монгол Улсын Их Сургуулийн дүрэм"-ийг хавсралт ёсоор баталж, 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн даган мөрдсүгэй.

2.Дүрмийг шинэчлэн баталсантай холбогдуулан МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан "МУИС-ийн дүрэм"-ийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.РЭГДЭЛ



МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 6 дугаар сарын 14 –ний өдрийн хурлаар хэлэлцэн 08 дугаар тогтоолоор батлав.

1117144746

УХД0072 9104399

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Их Сургууль (цаашид “МУИС” гэх)-ийн үндсэн үйл ажиллагааг бүтээмжтэй, үр нөлөөтэй, ил тод, хууль ёсны дагуу хэрэгжүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино. Хуулиар тусгайлан зохицуулаагүй харилцааг энэ дүрмээр зохицуулна.
- 1.2. МУИС нь 1942 онд байгуулагдсан, нийтийн өмчид суурилсан, хамтын болон өөрийн удирдлагатай, үндэсний хэмжээний бие даасан хуулийн этгээд мөн.
- 1.3. МУИС-ийн захиргаа Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлана. МУИС-ийн хаяг нь “Монгол Улс, Улаанбаатар хот, 14201, Монгол Улсын Их Сургууль (National University of Mongolia), Их сургуулийн гудамж-1”, цахим хуудас нь www.num.edu.mn болно.
- 1.4. МУИС тогтоосон журмын дагуу үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, өөрийн бэлгэдэлтэй байна.
- 1.5. МУИС-ийн үйл ажиллагаанд дараах үндсэн зарчмыг баримтална.
 - 1.5.1. Хууль дээдлэх;
 - 1.5.2. Эрдмийн эрх чөлөөг эрхэмлэх;
 - 1.5.3. Бие даасан байдлыг хангах;
 - 1.5.4. Шударга ёсыг сахих;
 - 1.5.5. Хариуцлагатай, ёс зүйтэй байх.

ХОЁР. МУИС-ийн үндсэн чиг үүрэг

- 2.1. Шинжлэх ухаан, технологийн ололт, сургалтын нийтлэг шаардлага, нийгмийн эрэлтэд тулгуурласан бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхэлж, мэргэжлийн болон иргэний өндөр боловсролтой мэргэжилтэн бэлтгэх, чадавхижуулах;
- 2.2. Шинжлэх ухааны судалгаа хийх, шинэ мэдлэг бүтээж сургалт, судалгаанд нэвтрүүлэх, инновацийн бодлого хэрэгжүүлэх;
- 2.3. Нийгэмд эрдэм мэдлэг түгээх, соён гэгээрүүлэх, Монгол Улсын хөгжил дэвшилд чиглэсэн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад шаардлагатай шинжлэх ухааны үндэслэлтэй санал зөвлөмж боловсруулж дэвшүүлэх;
- 2.4. Монголын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, үндэсний хэл, соёл, түүхийн дархлааг бэхжүүлэх хүрээнд монгол судлалыг хөгжүүлэх;
- 2.5. Багш, ажилтан, суралцагчдын ажиллах, суралцах хэвийн нөхцлийг бүрдүүлэх, эрхийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого хэрэгжүүлэх.

ГУРАВ. МУИС-ийн бүтэц

- 3.1. МУИС нь хэвийн, тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангасан зохион байгуулалт, бүтэцтэй буюу сургалт, судалгааны нэгж (бүрэлдэхүүн, салбар, төгсөлтийн дараах сургууль, тэнхим, хүрээлэн, төв, лаборатори, ахлах сургууль)-тэй байна.
- 3.2. Салбар сургууль нь нийслэлээс бусад засаг захиргааны нэгжид байрлаж МУИС-ийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь эсвэл тодорхой хэсгийг гүйцэтгэнэ.
- 3.3. МУИС-ийн үндсэн үйл ажиллагааны хэрэгжилтийг дэмжих чиг үүрэг бүхий үйлчилгээний нэгжтэй байна. Үйлчилгээний нэгжийн ажил үүргийг гадны байгууллагад гэрээгээр шилжүүлж болно.
- 3.4. МУИС-ийн сургалт, судалгааны нэгжийг байгуулах, өөрчлөн байгуулахтай холбоотой асуудлыг дор дурдсанаар шийдвэрлэнэ.
 - 3.4.1. МУИС-ийн салбар, харьяа байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

3.4.2. МУИС-ийн захиргааны бүтэц, бүрэлдэхүүн сургууль, тэнхим байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг МУИС-ийн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

3.4.3. Энэхүү дүрмийн 3.4.1, 3.4.2-д зааснаас бусад МУИС-ийн нэгжийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг МУИС-ийн захирлын баталсан тусгай журмаар зохицуулна.

3.5. МУИС-ийн бүрэлдэхүүн болон салбар сургуулиуд батлагдсан төсвийн хүрээнд бие даан ажиллаж, ажлынхаа чанар, үр дүнг сургуулийн удирдлагын өмнө хариуцна.

3.6. МУИС-ийн харьяа байгууллага (ахлах сургууль, Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан эрдэм шинжилгээний хүрээлэн) нь бие даасан хуулийн этгээд байна.

3.7. Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан эрдэм шинжилгээний хүрээлэн эрдмийн зөвлөлтэй байна. Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг МУИС-ийн захирал батална.

3.8. Хүрээлэнгийн захирлыг сонгон шалгаруулж МУИС-ийн захирал томилно. Хүрээлэнгийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга нь үндсэн орон тооны ажилтан байна.

ДӨРӨВ. МУИС-ийн удирдлагын тогтолцоо

4.1. Удирдах зөвлөл

4.1.1. МУИС хуульд заасны дагуу үүсгэн байгуулагч, багш, төгсөгч, суралцагчийн төлөөллөөс бүрдсэн 3 жилийн хугацаагаар ажиллах удирдах зөвлөлтэй байна.

4.1.2. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн дэх 51-60 хувь нь үүсгэн байгуулагчийн, бусад нь багш, суралцагч, төгсөгчдийн төлөөлөл байна.

4.1.3. Удирдах зөвлөлийн дарга, дэд даргыг үүсгэн байгуулагчийн саналыг харгалзан 3 жилийн хугацаагаар зөвлөлийн хурлаас ил санал хураалтаар сонгох ба нарийн бичгийн даргыг удирдах зөвлөлийн хурлаас томилно.

4.1.4. МУИС-ийн Удирдах зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.4.1. МУИС-ийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг хэлэлцэн батлах, өөрчлөх;

4.1.4.2. Захирлын саналыг үндэслэн МУИС-ийн дүрэм, түүний нэмэлт өөрчлөлт, бүтэц, зохион байгуулалтыг хэлэлцэн батлах;

4.1.4.3. МУИС-ийн жилийн төсөв, хөрөнгө оруулалтын хуваарийг баталж, гүйцэтгэл, зарцуулалтад хяналт тавих, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив авах журам тогтоох;

4.1.4.4. Сургалтын болон оюутны байрны төлбөрийн хэмжээг хэлэлцэн батлах;

4.1.4.5. МУИС-ийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, үнэлэх, дүгнэх;

4.1.4.6. Захирлыг томилох, чөлөөлөх саналыг үүсгэн байгуулагчид тавих;

4.1.4.7. Элсэгчдийн тоог тогтоох;

4.1.4.8. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайлан гаргаж, үүсгэн байгуулагчид өгөх.

4.1.5. Удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааны дүрэмтэй байна.

4.1.6. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг тухайн жилийн төсөвт тусгана.

4.1.7. МУИС-ийн санхүүгийн бодлого, стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, төсвийн орлогын бүрдэлт, зарцуулалтад хяналт тавих үүрэг бүхий орон тооны дотоод аудиторыг удирдах зөвлөлөөс томилж ажиллуулна. Шаардлагатай нөхцөлд мэргэжлийн байгууллагын туслалцаа авч болно.

4.2. Эрдмийн зөвлөл

4.2.1. МУИС нь эрдэм шинжилгээ, сургалт, нийгмийг соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтоож, түүний онол, арга зүйн түвшин, ач холбогдол, үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий докторын зэрэгтэй багш нарын төлөөллөөс бүрдсэн эрдмийн зөвлөлтэй байна. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулна.

4.2.2. Эрдмийн зөвлөл нь профессор, дэд профессор, зөвлөх профессор, зөвлөх дэд

профессорын зэрэглэлд ажиллаж буй багш нарын төлөөллөөс бүрдэнэ. Эрдмийн зөвлөл 71 гишүүнтэй байна. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 60 хүртэлх хувь нь профессор, 30 хүртэлх хувь нь дэд профессор, 10 хүртэлх хувь нь зөвлөх профессор, зөвлөх дэд профессор байна.

4.2.3. МУИС-ийн захирал, дэд захирлууд, Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирлууд эрдмийн зөвлөлийн гишүүн байна.

4.2.4. МУИС-ийн эрдмийн зөвлөлийн гишүүнийг бүрэлдэхүүн, салбар сургуулийн докторын зэрэгтэй үндсэн орон тооны багш болон зөвлөх профессор, зөвлөх дэд профессорын гуравны хоёроос доошгүй ирцтэй хурлаас нууц санал хураалтаар сонгоно.

4.2.5. Эрдмийн зөвлөлд сонгох гишүүний тоо нь бүрэлдэхүүн, салбар сургууль бүрт ногдох тогтмол орон тоо, тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн профессор, дэд профессорын албан тушаалын зэрэглэлд ажиллаж буй үндсэн орон тооны багш болон зөвлөх профессор, дэд профессорын тоонд нийцүүлэн жишсэн нэмэлт орон тооноос бүрдэнэ.

4.2.6. МУИС-ийн эрдмийн зөвлөлийн гишүүний сонгуулийг 3 жил тутамд явуулна.

4.2.7. Эрдмийн зөвлөлийн гишүүн нэг хичээлийн жилээс дээш хугацаагаар эзгүй байх эсвэл сул орон гарсан тохиолдолд тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн сонгуулийн жагсаалтын дараагийн нэр дэвшигч гишүүн болно.

4.2.8. Эрдмийн зөвлөл нь дарга, эрдэмтэн нарийн бичгийн даргатай байна. Эрдмийн зөвлөлийн дарга нь МУИС-ийн захирал байна.

4.2.9. Эрдмийн зөвлөл нь чиг үүргийн дагуу төрөлжсөн хороодтой байж болно.

4.2.10. Эрдмийн зөвлөл дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.10.1. МУИС-ийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг хэлэлцэж санал дүгнэлтээ захиргаа, удирдах зөвлөлд хүргүүлэх;

4.2.10.2. МУИС-ийн дүрэм, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн саналаа захиргаагаар уламжлан удирдах зөвлөлд хүргүүлэх;

4.2.10.3. МУИС-ийн сургалт, судалгааны бодлого, үйл ажиллагаатай холбоотой журмуудыг хэлэлцэж, өөрчлөлт оруулах саналаа захиргаанд хүргүүлж, шийдвэрлүүлэх;

4.2.10.4. МУИС-ийн хичээлийн жилийн тайланг хэлэлцэх;

4.2.10.5. МУИС-ийн эрдмийн цол, хүндэтгэл олгох;

4.2.10.6. МУИС-ийн захирлын үйл ажиллагааны талаар саналаа удирдах зөвлөлд оруулах;

4.2.10.7. Боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэлэлцэх, дүгнэлт гаргах;

4.2.10.8. Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;

4.2.10.9. Сургалтын хөтөлбөрийн бодлого, зөвлөмж боловсруулах, бүх шатны сургалтын хөтөлбөр боловсруулах, батлах, үнэлэх үүрэг бүхий Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааны талаар хэлэлцэж, дүгнэлт гаргах.

4.2.11. Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулна.

4.3. Захирал

4.3.1. Захирал нь МУИС-ийг төлөөлж, сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

4.3.2. Захирлын албан тушаалд тавих шаардлагыг боловсролын тухай хуулийн холбогдох заалтын дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан ажлын байрны тодорхойлолтоор тогтооно.

4.3.3. Захирал сургуулийн удирдлагыг Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрэм, үүсгэн байгуулагчтай байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлнэ.

4.3.4. Захирал нь ажлын байрны тодорхойлолт, албан тушаалд тавигдах шаардлагыг үндэслэн үйл ажиллагааны үндсэн чиглэлээр дэд захирлуудыг томилно.

4.3.5. Захирлыг эзгүй байх хугацаанд албан үүргийг нь аль нэг дэд захирал түр орлон гүйцэтгэнэ. Түр орлосон этгээдийн гаргасан шийдвэрийн хариуцлагыг захирал хүлээнэ.

4.3.6. МУИС нь үйл ажиллагааны чиглэлээр газар, хэлтэс, албатай байх эдгээр нэгжийн орон тоо, удирдлагыг холбогдох дэд захирлын саналыг үндэслэн захирал батална.

4.3.7. МУИС-ийн захирал бүрэн эрхээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах, захиргааны шуурхай удирдлагыг хангахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй захиргааны зөвлөл захирлын дэргэд ажиллана. Захиргааны зөвлөлд асуудал эрхэлсэн дэд захирал, газрын дарга, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал орно.

4.3.8. Захирал нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.3.8.1. Дээд боловсрол, шинжлэх ухаан, технологийн талаарх төрийн бодлогод нийцүүлэн сургуулийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах;

4.3.8.2. Хууль тогтоомжийн дагуу МУИС-ийн дүрэм, түүнд холбогдох өөрчлөлт, бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, өөрчлөх, татан буулгах саналаа удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх;

4.3.8.3. МУИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургууль, харьяа байгууллагын тайланг сонсож, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;

4.3.8.4. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн МУИС-д мөрдөх журмуудыг боловсруулах, батлах, мөрдүүлэх;

4.3.8.5. Багш, ажилтны ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилд томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, биелэлтийг дүгнэх, цуцлах;

4.3.8.6. Сургуулийг хөгжүүлэх хөрөнгө, хандив, сургуулийн санхүү, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;

4.3.8.7. МУИС-ийн гадаад харилцааны бодлогыг тодорхойлж, бусад орны их дээд сургууль эрдэм шинжилгээний байгууллагатай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

4.3.8.8. Суралцагч элсүүлэх, шилжүүлэн суралцуулах, чөлөөлөх, төгсгөх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх.

4.4. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн удирдлага

4.4.1. Бүрэлдэхүүн, салбар сургууль эрдмийн зөвлөлтэй байна.

4.4.1.1. Бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөл нь тухайн сургуулийн профессор, дэд профессор, зөвлөх профессор, зөвлөх дэд профессорын зэрэглэлд ажиллаж буй багш нарын 50 хувийн төлөөллөөс бүрдэнэ. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 60 хүртэлх хувь нь профессор, 30 хүртэлх хувь нь дэд профессор, 10 хүртэлх хувь нь зөвлөх профессор, зөвлөх дэд профессор байна.

4.4.1.2. Эрдмийн зөвлөлийн гишүүнийг тухайн сургуулийн докторын зэрэгтэй үндсэн орон тооны багш болон зөвлөх профессор, зөвлөх дэд профессорын гуравны хоёроос доошгүй ирцтэй хурлаас нууц санал хураалтаар сонгоно.

4.4.1.3. Бүрэлдэхүүн сургуулийн захирал эрдмийн зөвлөлийн дарга байна. Эрдмийн зөвлөлийн гишүүдээс нарийн бичгийн даргыг сонгоно.

4.4.1.4. Бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөл нь МУИС-ийн эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдлөг болгоно.

4.4.2. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн эрдмийн зөвлөл дараах чиг үүрэгтэй.

4.4.2.1. Бүрэлдэхүүн сургуулийн сургалт, судалгааны тэргүүлэх чиглэлийг тогтоох, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг хэлэлцэн санал дэвшүүлэх;

4.4.2.2. Бүрэлдэхүүн сургуулийн цол олгох асуудлаар шийдвэр гаргах;

4.4.2.3. МУИС болон бүрэлдэхүүн сургуулийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа судалгааны төслийн явц, тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх;


4.4.2.4. Тухайн сургуулийн эрдэмтдийн боловсруулсан эрдэм шинжилгээний төсөл, суурь судалгааны талаар дүгнэлт гаргах;

4.4.2.5. Багш нарт бүтээлийн чөлөө олгох асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах, үр дүнг хэлэлцэж дүгнэлт гаргах;

4.4.2.6. Бүрэлдэхүүн сургуулийн захирлын үйл ажиллагааны талаар саналаа МУИС-ийн захиралд гаргах.

4.4.3. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдана.

4.4.3.1. Бүрэлдэхүүн сургуулийн захирал нь докторын зэрэгтэй, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан байх бөгөөд үүний 3-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан байна.



4.4.3.2. Бүрэлдэхүүн сургуулийн захирлыг судлан шалгаруулах ажлын хэсгийг МУИС-ийн захирлын тушаалаар байгуулна. Ажлын хэсэг шаардлага хангасан нэр дэвшигчдийг тодруулж, үндсэн орон тооны багш болон зөвлөх профессор, зөвлөх дэд профессор нарын 50-иас дээш хувийн ирцтэй хурлаар нууц санал хураалт явуулж, хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигчээс МУИС-ийн захирал сонгон томилно.

4.4.3.3. Бүрэлдэхүүн сургуулийн захирлыг 3 жилийн хугацаагаар томилно. Захирал бүрэн эрхийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө ажлын тайлангаа үндсэн орон тооны багш болон зөвлөх профессор, зөвлөх дэд профессор нарын хуралд хэлэлцүүлнэ. Захирлын ажлыг нууц санал хураалтаар үнэлнэ. Захирлын ажлыг олонх нь хангалттай гэж үзвэл 1 удаа үргэлжлүүлэн ажиллуулах үндэслэл болно.

4.4.3.4. Захирал эрх, үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах, захиргааны шуурхай удирдлагыг хангахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийг ажиллуулна.

4.4.4. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.4.4.1. МУИС-ийн нэгдсэн бодлого, стратеги төлөвлөгөөний дагуу бүрэлдэхүүн сургуулийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулах, мөрдөж ажиллах, хэрэгжилтийг хангах, сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

4.4.4.2. Бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд сургалтын үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангаж, шаталсан сургалтын хөтөлбөрүүдийг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх ажил, магистрант, докторантуудыг сургалт, судалгааны туслахаар ажиллуулах асуудлыг зохион байгуулах;

4.4.4.3. Бүрэлдэхүүн сургуулийн судалгааны бодлого боловсруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төсөл, хөтөлбөрийн тоо, чанарыг сайжруулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах чиглэлээр санаачлагатай ажиллаж, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг олон нийтэд сурталчлах, сургалт, судалгааны ажлын нэгдлийг хангах;

4.4.4.4. МУИС-ийн захирлаас шилжүүлсэн эрхийн хүрээнд бүрэлдэхүүн сургуулийн санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, ил тод мэдээлэх, олон эх үүсвэрт санхүүгийн тогтолцоог бий болгох, сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэх, багш, ажилтан, суралцагчдын ажиллах, суралцах таатай орчин, хэвийн нөхцлийг хангах;

4.4.4.5. МУИС-ийн захирлаас шилжүүлсэн эрхийн хүрээнд бүрэлдэхүүн сургуулийн суралцагчтай холбоотой /сургалтын гэрээ байгуулах, жилийн чөлөө олгох, үргэлжлүүлэн суралцуулах/ асуудлыг шийдвэрлэх, багш, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээг цуцлах, чөлөө олгох, үргэлжлүүлэн ажиллуулах саналыг МУИС-ийн захиргаанд уламжлах;

4.4.4.6. Бүрэлдэхүүн сургуулийг төлөөлж, гадаад, дотоодын их, дээд сургууль, байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулах;

4.4.4.7. Тэнхим, лаборатори, төвийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, тэдгээрийн удирдлагыг өөрчлөх асуудлаар МУИС-ийн захиралд санал оруулах;


4.4.4.8. Сургууль нийгмийн харилцаа холбоог хөгжүүлэх, төгсөгчдийг ажлын байраар хангах, мэргэжил дээшлүүлэх, төгсөгчдийг дэмжиж, хамтран ажиллах;

4.4.4.9. Хичээлийн жил бүр ажлын төлөвлөгөө боловсруулан мөрдөж, биелэлтийг хамт олны хуралд тайлагнах.

4.5. Тэнхим

4.5.1. Тэнхимийн эрхлэгч нь тухайн салбараар мэргэшсэн, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 6-аас доошгүй жил ажилласан, профессор, дэд профессорын зэрэглэлд 3-аас доошгүй жил ажилласан байна.

4.5.2. Тэнхимийн эрхлэгчийг тэнхимийн үндсэн орон тоон дээр ажиллаж буй багш болон зөвлөх профессор, зөвлөх дэд профессор нарын 50-иас дээш хувийн ирцтэй хурлаар нууц



санал хураалт явуулж, хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигчээс МУИС-ийн захирал сонгон томилно.

4.5.3. Тэнхимийн эрхлэгчийг 2 жилийн хугацаагаар томилно. Эрхлэгч бүрэн эрхийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө ажлын тайлангаа тэнхимийн үндсэн орон тооны багш болон зөвлөх профессор, зөвлөх дэд профессор нарын хуралд хэлэлцүүлнэ. Эрхлэгчийн ажлыг нууц санал хураалтаар үнэлэх ба олонх нь хангалттай гэж үзвэл 2-оос ихгүй удаа үргэлжлүүлэн ажиллуулах үндэслэл болно.

4.5.4. Тэнхимийн шийдвэр гаргах хэлбэр нь тэнхимийн хурал байна. Багш нарын гуравны хоёроос доошгүй ирцтэй хурлаар олонхийн саналаар шийдвэр гаргана.

4.5.5. Тэнхимийн эрхлэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.5.5.1. Тэнхимийн сургалт, судалгааны үйл ажиллагааг үр ашигтай, хариуцлагатай удирдан зохион байгуулах;

4.5.5.2. Мэргэжил, хөтөлбөрөө сурталчлах, гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх;

4.5.5.3. Тэнхимийн багш, ажилтны мэргэжлийн үйл ажиллагаа, ёс зүйн байдалд дүгнэлт өгөх, зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцох талаар дээд шатны удирдлагад санал оруулах;

4.5.5.4. Тэнхимийн сургалт, судалгааны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, дүгнэлт гаргуулах, үр дүнг тэнхимийн хурлаар хэлэлцүүлэх;

4.5.5.5. Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс тэнхимийн хичээлийн хуваарь, оюутны сонголтонд үндэслэн багш, анги тэнхимийн хүрэлцээ, сургалтын техник тоног төхөөрөмжийн хангамж, хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллах;

4.5.5.6. Тэнхимийн харьяалалд байгаа ерөнхий суурь, үндсэн мэргэжил, хавсарга мэргэжил, хос мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, оюутан суралцагчдыг шаардлагатай мэдээллээр хангах, энэ чиглэлийн оюутанд үзүүлэх үйлчилгээг сайжруулах;

4.5.5.7. Хичээлийн жил бүр ажлын төлөвлөгөө боловсруулан мөрдөж, биелэлтийг тэнхимийн хамт олны хуралд тайлагнах.

ТАВ. МУИС-ийн багш, ажилтан

5.1. МУИС-ийн багш, ажилтан яс үндэс, уг гарал, шашин шүтлэг, нас, хүйс, улс төрийн үзэл бодол, гэр бүлийн байдал зэрэг ямар нэгэн ялгаварлал, давуу тал, гадуурхлаас ангид байна.

5.2. Багш, ажилтан хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, хүчин төгөлдөр мөрдөж буй журмууд, “МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдөн ажиллана.

5.3. Багш, ажилтан хууль тогтоомжийн дагуу тухайн ажлын байрны тодорхойлолт, ажлын шаардлагад заасан ажил үүргийг захирал буюу түүний эрх олгосон этгээдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

5.4. Багш, ажилтны сул орон тоог нээлттэй зарлаж, сонгон шалгаруулж авна.

5.5. Багш, эрдэм шинжилгээ, сургалт, захиргаа, үйлчилгээний нэгжийн ажилтны үйл ажиллагааг үнэлэх аттестатчиллыг тусгай журмаар зохицуулна.

5.6. МУИС-ийн багш тухайн салбараар мэргэшсэн, тодорхой чиглэлээр судалгаа явуулдаг, магистр, түүнээс дээш зэрэгтэй байна. Ахисан түвшний сургалтанд оролцох багш докторын зэрэгтэй байна.

5.7. Багшийн албан тушаал, цол, мэргэжлийн үнэлэмжийг сургалт, судалгаа, нийгмийн болон инновацийн үйл ажиллагаанд оруулсан хувь нэмрээр тодорхойлно.

5.8. МУИС-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн, төв нь чадварлаг судлаачдад нээлттэй байх ба үндсэн болон гэрээт эрдэм шинжилгээний ажилтнаас бүрдэнэ. Үндсэн орон тоонд ажиллах эрдэм шинжилгээний ажилтан докторын зэрэгтэй байна.

5.9. МУИС-ийн багш холбогдох хууль тогтоомжид заасан эрхийг эдлэхээс гадна:

5.9.1. Эрдэм шинжилгээний бүтээлээ дотоод, гадаадын шинжлэх ухааны хэвлэлд нийтлүүлэх;


5.9.2. МУИС-ийн мэдээллийн болон материалын нөөцийг албан зориулалтаар ашиглах;

- 5.9.3. Хамтын хөдөлмөрийн гэрээнд заасан зохих нөхцөл, журмын дагуу цалинтай бүтээлийн чөлөө авах, ажлаас түр чөлөөлөгдөх;
- 5.9.4. МУИС-ийн дэмжлэгтэйгээр боловсрол, мэргэшлээ дээшлүүлэх;
- 5.9.5. МУИС-ийн удирдах байгууллагад сонгогдох, сонгох;
- 5.9.6. Дотоод, гадаадын мэргэжлийн байгууллагад элсэх;
- 5.9.7. МУИС-ийн үйл ажиллагааны талаар санал дүгнэлт гаргах, холбогдох байгууллагад тавих эрхтэй.
- 5.10. Багш холбогдох хууль тогтоомжид заасан үүрэг хүлээхээс гадна:
- 5.10.1. Ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ биелүүлэх;
- 5.10.2. Хамт ажиллагчид болон суралцагчидтай хүндэтгэлтэй, шударга, ёс зүйтэй хандах;
- 5.10.3. МУИС-ийн сургалт, судалгааны хүч хөрөнгөөр бий болсон оюуны бүтээлийг бусдад зүй бусаар ашиглуулахгүй байх үүрэгтэй.
- 5.11. Ажилтны эрх үүргийг Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, сургуулийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолтоор тогтооно.

ЗУРГАА. МУИС-ийн суралцагч

- 6.1. МУИС нь Монгол Улсын болон гадаадын иргэн, яс үндэс, уг гарал, нас, хүйс, шашин шүтлэг, нийгмийн байдлыг харгалзахгүйгээр элсэн суралцах шаардлагыг хангасан нөхцлөөр суралцуулна.
- 6.2. Сурацлагч хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, хүчин төгөлдөр мөрдөж буй журмууд, “МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдөн ажиллана.
- 6.3. Суралцагч (ахлах сургуулийн сурагч, бакалавр, магистр, докторын түвшний суралцагч) нь хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, хүчин төгөлдөр мөрдөж буй журмуудыг дагаж мөрдөнө.
- 6.4. Суралцагчдыг элсүүлэх, суралцуулах, төгсгөх асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн МУИС-ийн холбогдох журам болон захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 6.5. Суралцагч холбогдох хууль тогтоомжид заасан эрхийг эдлэхээс гадна:
- 6.5.1. МУИС-ийн материаллаг болон мэдээллийн нөөцийг сургалт, эрдэм шинжилгээний зориулалтаар ашиглах;
- 6.5.2. Шинжлэх ухааны хөгжлийн орчин үеийн ололтоос суралцах;
- 6.5.3. Шинжлэх ухааны мэдлэг эзэмших зорилгоор профессор, багш нараас зөвлөгөө авах, эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд оролцох;
- 6.5.4. МУИС-ийн үйлчилгээний нэгжүүдээс зохих журам, нөхцлийн дагуу үйлчилгээ авах;
- 6.5.5. Сургалтын чанарын талаар саналаа илэрхийлэх;
- 6.5.6. Хууль тогтоомж болон сургуулийн дүрэм, журмын дагуу сургуулийн удирдах байгууллагад сонгогдох, сонгох;
- 6.5.7. Хууль тогтоомжид нийцсэн үйл ажиллагаа явуулах эрхтэй.
- 6.6. Суралцагч холбогдох хууль тогтоомжид заасан үүрэг хүлээхээс гадна:
- 6.6.1. Сургалтын хөтөлбөрт заасан бүх хэлбэрийн үйл ажиллагаанд идэвхтэй, тогтмол оролцох;
- 6.6.2. Сургалтанд шаардагдах хичээлийн хэрэглэгдэхүүнээр өөрийгөө хангах үүрэг хүлээнэ.
- 6.6.3. Багш, ажилтан, бусад суралцагчдад хүндэтгэлтэй хандах;
- 6.6.4. МУИС-д хүчин төгөлдөр үйлчилж байгаа дүрэм, журмыг баримтлах;
- 6.6.5. МУИС-ийн хүрээнд ёс зүй, эерэг зан үйлийг чандлан сахих, эрдмийн нэр хүндийг хүндэтгэх үүрэгтэй.
- 6.7. МУИС-ийн дүрэм журмыг зөрчсөн нь тогтоогдсон суралцагчийг сануулах, сургуулиас хасахаар сануулах, сургуулиас хасах арга хэмжээг бүрэлдэхүүн сургуулийн захирлын саналыг үндэслэн МУИС-ийн захирал шийдвэрлэнэ.

ДОЛОО. Багш, ажилтан, суралцагчийн байгууллага



- 7.1. МУИС-ийн багш, ажилтан, суралцагч, төгсөгчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой, сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн байгууллага өөрийн удирдлагын зарчимд тулгуурлан ажиллаж болно.
- 7.2. Багш, ажилтан, суралцагч, төгсөгчдийн байгууллага нь зөвхөн МУИС-ийн багш, ажилтан, суралцагч, төгсөгчдийн төлөөллөөс тус тус бүрдэнэ.
- 7.3. Багш, ажилтан, суралцагч, төгсөгчдийн байгууллагын ажиллах журам МУИС-ийн дүрэм болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.
- 7.4. Багш, ажилтан, суралцагч, төгсөгчдийн байгууллага нь МУИС-ийн бодлого, үйл ажиллагааг төлөөлөх хуулийн этгээд болохгүй.
- 7.5. МУИС нь хуулийн хүрээнд эдгээр байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллаж болно.

НАЙМ. МУИС-ийн эдийн засгийн баталгаа

- 8.1. МУИС-ийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан урт хугацааны зорилго, зорилтын хүрээнд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагааг ил тод, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн тогтвортой, иж бүрэн, үнэн зөв, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлнэ.
- 8.2. МУИС-ийн төсөв дараах эх үүсвэрээс бүрдэнэ.
- 8.2.1. Татаас санхүүжилтийн орлого /улсын төсөв/;
 - 8.2.2. Сургалтын төлбөр;
 - 8.2.3. Эрдэм шинжилгээний төсөл, гэрээт болон захиалгат судалгааны ажлын санхүүжилт;
 - 8.2.4. Аж ахуйн үйл ажиллагааны орлого;
 - 8.2.5. Зохих журмын дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, төгсөгчдөөс өгсөн хандив тусламж;
 - 8.2.6. Зээл;
 - 8.2.7. Лицензийн болон патентын төлбөр;
 - 8.2.8. Хадгаламжийн болон харилцах дансны үлдэгдлийн хүү;
 - 8.2.9. Түрээсийн төлбөр;
 - 8.2.10. МУИС-ийн эндоумент сан;
 - 8.2.11. Хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн сургууль хөгжүүлэх сан;
 - 8.2.12. Хуульд нийцсэн санхүүгийн бусад эх үүсвэр.
- 8.3. МУИС-ийн эдийн засаг, санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг төсвийн шууд захирагч, асуудал эрхэлсэн дэд захирал, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал, бүртгэл санхүүгийн ажилтнууд хариуцан гүйцэтгэнэ.
- 8.4. Сургуулийн хөрөнгө, санхүүгийн нөөцийг төсвийн дагуу хуваарилж, зарцуулах бөгөөд төсвийн шууд захирагч удирдах зөвлөлөөс баталсан төсвийг захиран зарцуулна.
- 8.5. Төсвийн шууд захирагч төсвийн зарим хэсгийг захиран зарцуулах эрх мэдлээ гэрээний үндсэн дээр бүрэлдэхүүн сургуулийн захиралд шилжүүлж болно.
- 8.6. МУИС-ийн болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн төсвийн төсөл, төсөв, төсвийн гүйцэтгэл, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, санхүүгийн тайлан, түүнд хийсэн эдийн засгийн шинжилгээ, аудитын дүгнэлт, тендерийн баримт бичиг, шалгуур үзүүлэлт, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, худалдан авах үйл ажиллагааны тайланг хуульд заасан хугацаанд сургуулийн цахим хуудсанд байрлуулна.
- 8.7. Хуульд заасан хугацаанд санхүүгийн үйл ажиллагаандаа хөндлөнгийн аудитыг /санхүүгийн/ эрх бүхий байгууллагаар хийлгэж, үр дүнг удирдах зөвлөлд болон олон нийтэд ил тод мэдээлнэ.